



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 03

Хэрлэн сум

Аймгийн Онцгой комиссын III хурал 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 19:30 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 27 гишүүд оролцохоос 27 гишүүнтэй 100% ирцтэй хуралдав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Коронавирусын халдварын тархалтын нөхцөл байдалтай холбогдуулан мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн саналын дагуу холбогдох шийдвэрүүдийг гаргах.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газрын дарга нар, Хэрлэн, Баянтүмэн, Хөлөнбуйр, Баян-Уул сумдын Засаг дарга нарт:

1. Хөлөнбуйр суманд хот хоорондын хатуу хучилттай автозам дагуу хяналт, шалгалтын цэг байгуулахыг;
2. Баянтүмэнгийн гүүр, Ялалт гүүр, Модон гүүрүүдэд хяналт, шалгалтын цэгүүдийг байгуулахыг;
3. Баян-Уул суманд мэргэжлийн байгууллагуудаас бүрдсэн хяналт, шалгалтын цэг байгуулахыг;

Мэргэжлийн хяналтын газар, Гадаадын харъяатын Зүүн бүс дэх газрын дарга нар, Матад, Халхгол сумын Засаг дарга нарт

1. Гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхай, газрын тосны компаниудад зорчих хөдөлгөөн ихтэй автозамуудад өөрсдийн хүн хүч, техник хэрэгсэл, багаж төхөөрөмжөөр ариутгал хяналт, шалгалтын цэг байгуулахыг;

Мэргэжлийн хяналтын газар, Гаалийн газар, Эрүүл мэндийн газар,

Хилийн байгууллагын дарга нарт:

1. Хилийн Хавирга, Баянхошуу боомтоор БНХАУ руу зорчсон Монгол иргэдийг тухайн гарсан боомтоор буцаан оруулж ирэхийг;
2. Хилээр нэвтэрч оруулах Монгол иргэдэд асуумж авч, үзлэг тандалтыг хийж бүртгэлжүүлэх, шаардлагатай тохиолдолд тусгаарлан эмнэлгийн байгууллагад хүргэхийг;

3. Баянхошуу боомтоор Газрын тосны бүтээгдэхүүнийг гаргах тээвэрлэлт хийх Монгол жолоочтой автомашинуудыг БНХАУ руу нэвтрүүлэхгүй байх цаашид түр хугацаагаар тээвэрлэлтийг зогсоохыг;

4. БНХАУ-ын харьяалал бүхий иргэн, тээврийн хэрэгслийг түр хугацаагаар Монгол улс руу нэвтрүүлэхгүй байхыг;

Боловсрол, соёл урлагийн газрын дарга А.Нансалмаад:

1. БНХАУ-д суралцаж байгаа оюутнуудын судалгааг нарийвчлан гаргахыг,
2. Зах, томоохон худалдаа, үйлчилгээний газруудад тухайн өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл, ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулахыг;

Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг-д:

1. Дорнод аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа баар, ресторан, караоке, паб зэрэг үйлчилгээний байгууллагуудын цагийн хязгаарт түр өөрчлөлт оруулж 22:00 цаг хүртэл ажиллуулахыг;

Цагдаагийн газар, Онцгой байдлын газар,

Тагнуулын газрын дарга нарт:

1. Нийгмийн хэв журмыг сахиулах, иргэдийн аюулгүй байдал, дэг журмыг хангуулахыг;

Аймгийн Онцгой комиссын нийт гишүүдэд:

1. Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан хувийн бэлэн байдал, холбооны хэрэгслийн найдвартай ажиллагааг хангаж ажиллахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ, ОНЦГОЙ КОМИССЫН  
ОРЛОГЧ ДАРГА Ч.ГАНБАТ

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА Д.БАТТУЛГА

